**НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 02 сарын 18 өдөр Дугаар А/32 Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн Амгалан цогцолбор
сургуулийн данс бүртгэлээс хөрөнгө хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан "Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.6 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс"-ын 2019 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн хурлын шийдвэрийн дагуу эргэлтийн бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 12,482,992 /арван хоёр сая дөрвөн зуун наян хоёр мянга есөн зуун ерэн хоёр/ төгрөгийн бүртгэлийн үнэ бүхий хавсралтад заасан ном, сурах бичгийг акталж, данс бүртгэлээсээ хасахыг Баянзүрх дүүргийн Амгалан цогцолбор сургууль /Л.Баянтуул/-д зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хөрөнгийг байгууллагын Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналтан дор устгалын акт үйлдэн зохих журмын дагуу устгаж, өмчийн мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний холбогдох өөрчлөлт хийхийг Баянзүрх дүүргийн Амгалан цогцолбор сургууль /Л.Баянтуул/-д үүрэг болгосугай.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Өмчийн бүртгэл, мэдээллийн хэлтэс /Д.Итгэл/-т даалгасугай.

ДАРГА Ч.ОДНАСАН

ТТА-2371

D:\Tushaal 2019-1\Tushaal-1\Тушаал 2019.docx

115050000103

Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын
2019 оны 02 дугаар сарын 18 -ны өдрийн
A/32 дугаар тушаалын хавсралт

# Данснаас хасах хөрөнгийн жагсаалт

Байгууллагын нэр: Баянзүрх дүүргийн Амгалан цогцолбор сургууль

| № | Эд хөрөнгийн нэр | Ашигласан жил | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн үнэ | Нийт үнэ | Байгуулсан элэгдэл | Үлдэгдэл үнэ | Эвдрэл гэмтэл | ӨХБЗ-ийн дүгнэлт | НӨХГ-ын мэргэжилтний санал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Ном, сурах бичиг | 3--9 | ш | 8101 | | 12,482,992 | | **12,482,992** | | | устгах |
| | **Номын фонд** | | | | | 12,482,992 | | **12,482,992** | | | |
| Үүнээс: Худалдах хөрөнгийн дүн | | | | | | | | | | | |
| Устгах хөрөнгийн дүн | | | | | | 12,482,992 | | | | | |
| Татан төвлөрүүлэх хөрөнгө | | | | | | | | | | | |
| Худалдсанаас олох орлого | | | | | | | | | | | |
| НӨХГ-т төвлөрүүлэх /30%/ | | | | | | | | | | | |

ТТА - 2371